



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/1/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: У.Энхчимэг

Утас: 7000-3775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



| | |
|---|----|
| Аудитын гэрчилгээ | 3 |
| Аудитын тайлан | 5 |
| 2.1. Оршил | 5 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага..... | 5 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт..... | 5 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 6 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 6 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал..... | 6 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 6 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд..... | 7 |
| 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | 8 |
| 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 8 |
| 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 9 |
| 2.13. Шилэн дансны мэдээлэл | 9 |
| 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт..... | 9 |
| 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 10 |
| Менежментийн захидал | 11 |
| Аудит хийгдсэн санхүүгийн тайлан..... | 13 |
| 4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан..... | 13 |
| 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 14 |
| 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 16 |
| 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 18 |



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.03.15 № 300
танай _____-ны № _____-т

ГЭРЭЛСЭТГЭМЖ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Б.ГЭРЭЛТ-ОД ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

110520211



Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын биелэлт хангалтгүй, үндсэн хөрөнгийн бүртгэлийг анхан шатны баримт бүрдэл дутуу хийсэн, жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогыг үнэн зөв хийгээгүй, хөрөнгийг бөөн дүнгээр бүртгэж элэгдлийг буруу тооцсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-дахь зүйлд заасан “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн эд хөрөнгийн тооллого хийх тухай 70-73 дугаар зүйлийг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, бодитой ба тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Гэрэлт-Од Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дүгээр сарын 07-ноос 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймгийн Төрийн аудитын газрын захиалгаар "Хаан консалтинг аудит" ХХК-ийн аудитор У.Энхчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Чойбалсан хотын хөгжил, цэцэрлэгжилт, өнгө үзэмжийг сайжруулж, иргэдийн эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэх, хотын гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх”-д оршино.

Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хотын нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэг, хаяг реклам, чимэглэл хийх, эзэмшилт, ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой **нийцээгүй байна**.

Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous программ хангамж ашигладаг байна.

Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөө багатай байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 39 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны

жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлын үзүүлэлтийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,083,352.5 мянган төгрөгөөс тооцон 21,667.05 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг мөн 21,667.05 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 276,786.12 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|----------------|-----------------|--------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 35.90 | 21.40 | (14.50) |
| Авлага | 735.00 | 273.10 | (461.90) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 7,058.37 | 18,761.99 | 11,703.62 |
| Үндсэн хөрөнгө | 4,477,230.10 | 5,145,741.98 | 668,511.87 |
| Хуримтлагдсан элэгдэл | (700,308.26) | (1,103,261.23) | (402,952.97) |
| Нийт хөрөнгө | 3,784,751.11 | 4,061,537.23 | 276,786.12 |
| Өр төлбөр | - | 1,423.70 | 1,423.70 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3,784,751.11 | 4,060,113.53 | 275,362.43 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 3,784,751.11 | 4,061,537.23 | 276,786.13 |

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь сэлбэг хэрэгслийн нөөц нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийгдсэн гэрэлтүүлгийн ажлуудыг хүлээн авснаас шалтгаалжээ. Хөрөнгө оруулалтаар 619,288.8 мянган төгрөг, шилжүүлж хүлээн авсан 40,927.8 мянган төгрөг, худалдан авсан 8,295.4 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь ХХОАТ, НӨАТ-ын өр үүссэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,060,113.53 мянган төгрөг болж 275,362.43 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгөөс өсөлтөөс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 512,501.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 512,501.0 мянган төгрөгийг урсгал зардалд, зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 512,501.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 512,501.0 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 11,731.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Тус орлогыг урсгалд зардалд зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 39 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 11 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 594,603.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 89,399.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 77,603.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 516,999.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,000.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 89,399.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. 2019 онд Дорнод аймгийн Санхүүгийн боловсрол сургалтын төвтэй 1 сая төгрөгийн гэрээ байгуулан НБББББ боловсруулж хүлээн авсан нь тус байгууллагын онцлог, үйл ажиллагаатай огт уялдаагүй, УСНББОУС-тай нийцээгүй, чанар стандартын шаардлага хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

2. Харьцуулалтын аргаар цахим тендер зарлаагүй 40.2 сая болон 30.2 сая төгрөгийн шууд гэрээ тус тус "Их говийн тэнгэр групп" ХХК -тай байгуулсан байгаа нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 5.1.3, 8.11 болон 8.4 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

3. Тус байгууллага "Төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журам"-ыг мөрдөж ажиллана гэж НБББББ-тээ заасан хэдий ч тус журамд заагдаагүй ажил гүйлгээг кассаар хийж байна. Тухайлбал худалдан

авалтын төлбөр тооцоог хийжээ. Кассын гүйлгээний 57.4 % нь материал худалдаж авсан гүйлгээ байгаа нь "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага өгөв.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй гол асуудлын талаар:

1. 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй. Үндсэн хөрөнгөнд "Хөрөнгө" нэртэй 426.6 сая төгрөгийн хөрөнгийг тодорхойгүй бүртгэсэн байна. Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллого хангалтгүй хийгдсэн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-74 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дугаар заалтыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн бодитой ба тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Аудитын тайлангийн санал дүгнэлтийг хязгаарлаж, Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар илэрсэн 77,603.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндсэн хөрөнгийн тооллого, их засвараас буусан хөрөнгийн бүртгэл, ашиглалт, кассын үйл ажиллагаа, худалдан авах ажиллагааг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Хэрлэн сумын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэл, хүлээн авсан баримт, бодитой эсэх асуудлыг анхаарал татахуйц асуудал гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 95 мэдээллийг хугацаанд нь, 52 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 718.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосноос 718.8 мянган төгрөгийг барагдуулсан, 1,102,506.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснээс 426,662.6 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.4 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын **агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс** урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хэрлэн сумын төсвийн хөрөнгөөр хийгдсэн 77,603,289.00 төгрөгийн 3 ажлыг хүлээлгэн өгсөн баримтгүйгээр үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

1.2. Эрсдэл:

Үндсэн хөрөнгийг баримтгүй, бодитоор хүлээлцэхгүй бүртгэж байгаа нь төсвийн хөрөнгөөр ажил бүрэн хийгдээгүй байх эрсдэлтэй.

1.3. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийг баримтыг үндэслэн бодитоор тоолж хүлээж авч, бүртгэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

2. НБББББ-тэй холбоотой асуудал

2.1.1 Илрүүлэлт:



Байгууллагын онцлогт тохирсон, хууль, холбогдох стандартад нийцсэн НБББББ-гүй байна.

1.5. Эрсдэл:

Нягтлан бодохын бүртгэлийн үйл ажиллагаанд алдаа гарах эрсдэлтэй.

1.6. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын онцлогт тохирсон, хууль, холбогдор стандартад нийцсэн НБББББ-ийг аудитын компанитай гэрээ байгуулан хийлгэх.

1.7. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|------------------|------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 7,829,305.17 | 19,056,528.16 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 35,919.36 | 21,440.78 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 18,539.36 | 21,440.78 |
| 3121 | Төгрөг | 18,539.36 | 21,440.78 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 18,539.36 | 21,440.78 |
| 33 | АВЛАГА | 735,016.44 | 273,100.19 |
| 335 | Бусад авлага | 735,016.44 | 273,100.19 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 735,016.44 | 273,100.19 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 7,058,369.37 | 18,761,987.19 |
| 351 | Түүхий эд материал | 6,963,369.37 | 18,666,987.19 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,963,369.37 | 18,666,987.19 |
| 354 | Хангамжийн материал | 95,000.00 | 95,000.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 95,000.00 | 95,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,776,921,800.79 | 4,042,480,745.32 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,776,921,800.79 | 4,042,480,745.32 |
| 392 | Биет хөрөнгө | 3,176,873,675.94 | 3,442,480,745.32 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,850,524,980.93 | 3,426,014,167.32 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -560,827,609.79 | -878,712,160.64 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 324,132,473.00 | 409,132,473.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -89,087,813.92 | -137,433,084.89 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 161,253,688.00 | 165,912,778.90 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -38,009,802.24 | -69,579,214.81 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 13,951,258.18 | 17,314,894.57 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -5,555,163.32 | -7,805,973.23 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 197,464,504.00 | 197,464,504.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 14,879,000.00 | 14,879,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,105,999.36 | -8,960,799.36 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 314,254,160.46 | 314,254,160.46 |
| 393 | Биет бус хөрөнгө | 600,048,124.85 | 600,000,000.00 |
| 39301 | Програм хангамж | 770,000.00 | 770,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -721,875.15 | -770,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 600,000,000.00 | 600,000,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,784,751,105.96 | 4,061,537,273.48 |
| 413 | Өр төлбөр | 00.00 | 1,423,739.55 |
| 41310 | Татварын өр | 00.00 | 1,423,739.55 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,784,751,105.96 | 4,060,113,533.94 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,784,751,105.96 | 4,060,113,533.94 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | |
| | | 3,280,183,952.50 | 3,280,183,952.50 |
| 51101 | Өмч: - төрийн | 3,280,183,952.50 | 3,280,183,952.50 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 174,657,134.63 | 450,019,562.61 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 174,657,134.63 | 174,657,134.63 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 329,910,018.83 | 329,910,018.83 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,784,751,105.96 | 4,061,537,273.48 |

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|---|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,588,684,326.61 | 1,358,715,013.71 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 977,668,532.85 | 846,213,949.74 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 977,668,532.85 | 846,213,949.74 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 977,668,532.85 | 846,033,596.39 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,462,083.18 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,168,000.00 | 11,731,918.19 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 967,038,449.67 | 834,301,678.20 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 611,015,793.76 | 512,501,063.97 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 60,338,000.00 | 00.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 60,338,000.00 | 00.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | 50,000,000.00 | 00.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 399,697,693.76 | 422,703,973.07 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 100,980,100.00 | 89,797,090.90 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 550,677,793.76 | 512,501,063.97 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 828,665,744.56 | 1,083,352,585.73 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 828,665,744.56 | 1,083,352,585.73 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 827,745,744.56 | 946,428,612.53 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 175,528,761.35 | 182,132,804.68 |
| 210101 | Үндсэн цалин | 172,528,761.35 | 182,132,804.68 |
| 210104 | Урамшуулал | 3,000,000.00 | 00.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 24,333,911.01 | 26,197,625.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,486,469.54 | 15,480,983.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,728,197.29 | 1,821,292.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,556,011.75 | 5,054,818.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 324,802.98 | 349,139.19 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,238,429.45 | 3,491,391.44 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 117,809,054.07 | 117,033,688.18 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 111,637,631.80 | 108,949,135.81 |
| 210302 | Түлш, халаалт | 69,300.00 | 1,610,616.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 102,122.27 | 833,936.37 |
| 210304 | Байрны түрээс | 6,000,000.00 | 5,640,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 54,251,805.22 | 22,433,371.25 |
| 210401 | Бичиг хэрэг | 575,338.48 | 1,264,253.99 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,728,379.10 | 19,908,884.10 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,026,084.66 | 941,910.87 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 25,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 25,848,302.34 | 00.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 48,700.64 | 318,322.29 |
| 2105 | Нормативт зардал | 3,161,500.00 | 10,072,727.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,161,500.00 | 10,072,727.20 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 105,138,661.54 | 162,654,286.04 |

| | | | |
|--------|--|-----------------|----------------|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,576,487.30 | 3,774,718.37 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,220,067.18 | 1,277,294.78 |
| 210604 | Урсгал засвар | 96,342,107.06 | 157,602,272.89 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 521,654.72 | 97,363.64 |
| 210702 | Дотоод албан томилолт | 521,654.72 | 97,363.64 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,206,652.28 | 22,173,177.01 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,093,227.28 | 18,775,454.01 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 800,000.00 | 1,518,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 774,825.00 | 822,240.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 184,800.00 | 301,483.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 154,000.00 | 286,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 120,000.00 | 215,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 79,800.00 | 74,200.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 340,793,744.37 | 403,633,569.15 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 70,000.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 340,723,744.37 | 402,952,969.15 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 920,000.00 | 136,923,973.20 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 920,000.00 | 360,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 920,000.00 | 360,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 760,018,582.05 | 275,362,427.98 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 868,326,763.47 | 00.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 520,117,865.27 | 00.00 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 348,208,898.20 | 00.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -868,326,763.47 | 00.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -108,308,181.42 | 275,362,427.98 |

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|---|---------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 656,419,565.00 | 556,232,060.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 10,828,265.00 | 13,318,760.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 10,828,265.00 | 13,318,760.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 10,828,265.00 | 13,318,760.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,660,265.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,168,000.00 | 13,318,760.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 645,591,300.00 | 542,913,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 645,591,300.00 | 542,913,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 64,771,800.00 | 00.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | 50,000,000.00 | 00.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 429,839,400.00 | 449,507,100.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 100,980,100.00 | 93,406,200.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 606,436,087.76 | 556,246,538.58 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 606,436,087.76 | 556,246,538.58 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 605,516,087.76 | 555,886,538.58 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 175,534,761.35 | 183,766,860.31 |
| 210101 | Үндсэн цалин | 172,534,761.35 | 183,766,860.31 |
| 210104 | Урамшуулал | 3,000,000.00 | 00.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 24,333,911.01 | 23,853,599.04 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,486,469.54 | 14,090,156.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,728,197.29 | 1,657,665.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,556,011.75 | 4,596,663.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 324,802.98 | 319,010.19 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,238,429.45 | 3,190,103.09 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 129,899,720.00 | 128,365,214.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 122,802,435.00 | 119,844,049.40 |
| 210302 | Түлш, халаалт | 388,080.00 | 1,421,019.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 109,205.00 | 896,145.00 |
| 210304 | Байрны түрээс | 6,600,000.00 | 6,204,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 31,431,849.00 | 23,287,236.05 |
| 210401 | Бичиг хэрэг | 670,933.00 | 1,258,602.01 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 29,440,772.00 | 20,457,321.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,115,131.00 | 1,025,906.96 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 83,150.00 | 24,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 121,863.00 | 325,406.08 |
| 2105 | Нормативт зардал | 3,199,500.00 | 3,600,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,199,500.00 | 3,600,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 224,783,121.40 | 166,447,197.95 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,365,670.00 | 935,372.74 |
| 210602 | Тавилга | 7,699,900.00 | 8,970,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 209,717,551.40 | 154,981,225.21 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 526,200.00 | 101,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 526,200.00 | 101,800.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 15,737,025.00 | 25,784,031.23 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,341,600.00 | 19,230,454.01 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 800,000.00 | 1,518,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 774,825.00 | 822,240.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 184,800.00 | 301,483.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 154,000.00 | 286,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 132,000.00 | 236,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 9,270,000.00 | 3,314,354.22 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 79,800.00 | 74,200.00 |



Гэрэлсэтгэмж ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|--------|---|----------------|------------|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 70,000.00 | 680,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 70,000.00 | 680,600.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 920,000.00 | 360,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 920,000.00 | 360,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 920,000.00 | 360,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 49,983,477.24 | -14,478.58 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 50,000,000.00 | 00.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 50,000,000.00 | 00.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 50,000,000.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 50,000,000.00 | 00.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -50,000,000.00 | 00.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | -16,522.76 | -14,478.58 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 52,442.12 | 35,919.36 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 35,919.36 | 21,440.78 |



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-----------------------|--------------|--|
| 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,280,183,952.50 | 329,910,018.83 | 174,657,134.63 | 00.00 | 3,784,751,105.96 |
| 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,280,183,952.50 | 329,910,018.83 | 174,657,134.63 | 00.00 | 3,784,751,105.96 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,280,183,952.50 | 329,910,018.83 | 174,657,134.63 | 00.00 | 3,784,751,105.96 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 275,362,427.98 | 00.00 | 275,362,427.98 |
| 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,280,183,952.50 | 329,910,018.83 | 450,019,562.61 | 00.00 | 4,060,113,533.94 |

